



United States Embassy Ulaanbaatar
ART in Embassies Exhibition

Jo Fleming **Ozone Layer**, 2008
Acrylic and mixed media on canvas, Diptych: 60 x 32 in.
Courtesy of the artist, Great Falls, Virginia

Жөү Флеминг **Озоны давхрага**, 2008
Зотон дээрх акрил ба холимог техник, Дэлгэцтэй самбар: 152,4 x 81,3 см
Уран бүтээлчийн зөвшөөрөл олгосон, Грейт Уоллс хот, Виржиния муж

ART in Embassies



Established in 1963, the U.S. Department of State's office of ART in Embassies (ART) plays a vital role in our nation's public diplomacy through a culturally expansive mission, creating temporary and permanent exhibitions, artist programming, and publications. The Museum of Modern Art first envisioned this global visual arts program a decade earlier. In the early 1960s, President John F. Kennedy formalized it, naming the program's first director. Now with over 200 venues, ART curates temporary and permanent exhibitions for the representational spaces of all U.S. chanceries, consulates, and embassy residences worldwide, selecting and commissioning contemporary art from the U.S. and the host countries. These exhibitions provide international audiences with a sense of the quality, scope, and diversity of both countries' art and culture, establishing ART's presence in more countries than any other U.S. foundation or arts organization.

ART's exhibitions allow foreign citizens, many of whom might never travel to the United States, to personally experience the depth and breadth of our artistic heritage and values, making what has been called a "footprint that can be left where people have no opportunity to see American art."

"For fifty years, ART in Embassies has played an active diplomatic role by creating meaningful cultural exchange through the visual arts. The exhibitions, permanent collections and artist exchanges connect people from the farthest corners of an international community. Extending our reach, amplifying our voice, and demonstrating our inclusiveness are strategic imperatives for America. ART in Embassies cultivates relationships that transcend boundaries, building trust, mutual respect and understanding among peoples. It is a fulcrum of America's global leadership as we continue to work for freedom, human rights and peace around the world."

— John Forbes Kerry
U.S. Secretary of State

Элчин сайдын яамд дахь уран зураг



АНУ-ын Төрийн Департаментын Элчин сайдын яамд дахь уран зураг \ЭУЗ\-ийн алба нь 1963 онд байгуулагдсан бөгөөд соёл урлагийн өргөн хүрээний зорилтын дагуу түр хугацааны болон байнгын уран зургийн үзэсгэлэн хөтөлбөрүүд, хэвлэл нийтлэлүүд гарган үүгээрээ улс орныхоо олон нийттэй харилцах дипломат бодлогын хүрээнд онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Орчин үеийн уран зургийн музей нь дэлхий дахинаа хүртээл болох энэхүү хөтөлбөрийг даруй 10-аад жилийн өмнөөс зөгнөн бодитойгоор харж байсан юм. Ингээд 1960-аад оны эхээр, тухайн үед ерөнхийлөгч байсан Жон Ф. Кеннеди ЭУЗ-ыг албан ёсны хөтөлбөр болгон өөрөө хөтөлбөрийнхөө анхны удирдагчаар нь ажиллаж байсан түүхтэй. Эдүгээ ЭУЗ хөтөлбөр өргөжин тэлж, дэлхий дахинаа 200 гаруй газруудад байршилтай болсон бөгөөд АНУ-ын ЭСЯ, консул болон засаг захиргааны байгууллагуудын төлөөлөгчийн газруудад АНУ ба хүлээн авагч талын улс орны орчин үеийн уран зургийн бүтээлүүдээс сонгон шалгаруулж түр хугацааны болон байнгын уран зургийн үзэсгэлэнгүүдийг амжилттай зохион байгуулсаар ирсэн болно. Олны хүртээл болж буй үзэсгэлэнгүүд нь олон улсын үзэгч, сонирхогч, судлаачид буюу ард иргэд, оролцогч хоёр талын хоёулангийнх нь уран зураг болон соёл урлагийн онцлог шинж чанар, цар хүрээ, өвөрмөц төсөөлөл, төсөөтэй болон ялгаатай ойлголтуудыг өгдөгөөрөө өндөр ач холбогдолтой юм. Энэ ч утгаараа, ЭУЗ-ын хөтөлбөрийн үйл ажиллагаа нь АНУ-ын уран зургийн болон соёлын бусад ямар ч байгууллагуудаас илүү идэвхтэй бөгөөд олон улсад хүртээмжтэй байдгаараа онцлогтой.

ЭУЗ-ын үзэсгэлэнгүүд нь гадна дотны ямар ч улсын ард иргэд, тэр дундаа АНУ-д өөрийн биеээр хэзээ ч очиж үзээгүй хүмүүст нээлттэй байдаг бөгөөд уран зургийн соёлын өвөөр дамжуулан, АНУ-ын эрхэмлэн дээдэлдэг ойлголт концепцууд, үнэт зүйлс, соёлын хөгжил, түүний хэм хэмжээ, цар хүрээг өөрсдийнхөөрөө мэдрэн хүлээн авч, "Америкийн уран зургийн соёл гэж чухам юу вэ гэдгийг ойлгон, АНУ-д магадгүй хэзээ ч очих боломжгүй тийм хүмүүст бага ч гэсэн өөрсдийн сэтгэлгээний мөрөө үлдээх" утга учир бүхий хөтөлбөр болно.

"Өнгөрсөн 50 жилийн турш Элчин сайдын яамд дахь уран зургийн хөтөлбөр нь соёл урлагийн солилцоо, хамтын ажиллагаагаар дамжуулан олон улсын дипломат харилцааны хүрээнд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн юм. Уран зургийн үзэсгэлэнгийн үйл ажиллагаа, тэдний байнгын коллекцууд, уран зураачид, уран бүтээлчдийн солилцоо зэрэг хөтөлбөрүүдийн ачаар дэлхийн аль ч өнцөг буланд орших ард иргэд хоорондоо холбогдон хамтран ажиллах боломжтой болсон билээ. Хөтөлбөрийн хамрах хүрээг улам бүр өргөжүүлж, олон нийтийн оролцоог дэмжин ажиллах нь АНУ-ын хувьд хүлээх ёстой том үүрэг хариуцлага юм. Элчин сайдын яамд дахь уран зургийн хөтөлбөр хилийн чанадад эв найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлж, харилцан итгэлцэл, ойлголцол, хүндлэлийг бий болгосоор ирсэн билээ. Цаашид эрх чөлөө, хүний эрх, дэлхийн энх тайвны төлөө ажиллахад энэ хөтөлбөрийн зорилго бодлого чиглэгдсээр байх болно."

— Жон Форбс Керри
АНУ-ын Төрийн Нарийн Бичгийн Дарга

Light on Landscapes

I am so thrilled to feature the work of contemporary American artists in the public portion of the Ambassador's residence here in Ulaanbaatar. Although an increasing number of Mongolians live in urban settings, I find that many head to the countryside at every opportunity they get. With the assistance of the ART in Embassies curators, I tried to select works of art which remind us of some of the most wonderful aspects of nature: light slanting through trees and reflecting off water; the rich depth of an ocean or a deep blue sky; and the amazing variety of greens that one finds in a meadow in spring.

As you read the artists' statements in this catalogue, you will see how their works, though varied in medium and approach, consistently touch on the theme of Man's relationship with his surroundings. As one artist writes, "It is in the basics of our landscape that one can see and feel the beauty of the essential, the elements of land and sky, of nature and humanity coming together."

All of the works are abstract and intentionally open to interpretation, so that the viewer is fully engaged. This is particularly the case with the pieces by Jo Fleming, such as *Ozone Layer* and *Earth Meets Sky*, which resonate, as Mongolians think about how to balance a love of the environment with the need to develop the country, including through mining. I've supplemented the items loaned via the ART in Embassies program of the Department of State with works from my personal collection, also shown in the public areas, which I think carry on the *Light on Landscapes* theme.

The exhibition also includes a whimsical touch, as *Mongolian Family with Balloon Hats* – part of Addi Sommeck and Charley Eckert's global work – shows us how an American visitor to Mongolia re-imagined fancy Mongolian hats as balloons. These two artists traveled to thirty-four countries, photographing people laughing and having fun. Their wish was to emphasize the fact that all people are born with the ability to experience enjoyment.

We certainly hope that you enjoy all of the art in this exhibition!

Piper Anne Wind Campbell
U.S. Ambassador to Mongolia

Ulaanbaatar
October 2013

Байгалд туссан гэрэл

Улаанбаатарт суугаа Элчин сайдын өргөөний олон нийтэд нээлттэй хэсэгт орчин үеийн Америкийн уран бүтээлчдийн бүтээлүүдийг толилуулж байгаадаа би маш их баяртай байна. Хэдийгээр хот суурин газар суурьшин амьдрах Монголчуудын тоо улам нэмэгдсээр байгаа ч тэдний олонх нь боломж олдох л юм бол хөдөө рүү яардагийг би мэднэ. “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрийн зохицуулагчдын тусламжтайгаар би байгалийн хамгийн гайхалтай зарим өнгүүд, тухайлбал модны завсраар туссан, усны долгион дээр ойсон гэрэл, тэнгис далайн баялаг гүн өнгө, эсвэл гүн хөх тэнгэр, хаврын нугад харж болох олон төрлийн сонин содон ногоон өнгийг санагдуулам уран бүтээлүүдийг сонгохыг хичээсэн юм.

Та бүхэн энэ танилцуулгад багтсан уран бүтээлчдийн тайлбарыг уншаад тэдний уран бүтээл өөр өөр арга замаар дамжин хүн ба хүрээлэн буй орчны харилцааны сэдвийг хэрхэн хөндөж байгааг харах болно. Нэгэн уран бүтээлчийн хэлснээр “Амин чухал зүйлийн гоо үзэмж, газар тэнгэрийн бие махбодь, байгаль, хүн төрөлхтний сүлэлдээнийг харж мэдрэх чадвар нь бидэнд байгалиас заяасан байдаг”.

Энд тавигдсан бүтээлүүд бүгд хийсвэр бөгөөд үзэгчдийг бүрэн дүүрэн оролцуулахын тулд өөр өөрийнхөөрөө тайлбарлах боломжийг зориуд нээлттэй үлдээсэн. Ялангуяа Жөү Флемингийн “Озоны давхрага”, “Тэнгэр газрын зааг” зэрэг бүтээлүүд нь Монголчууд байгаль орчноо хайрлах хайрыг улс орноо хөгжүүлэх (түүний дотор уул уурхайгаар) хэрэгцээтэй яаж тэнцвэржүүлэх тухай бодож байгаа энэ цаг үетэй яв цав тохирч байна. Төрийн Департаментын “Элчин сайдын яамд дахь уран зураг” хөтөлбөрийн дагуу энд тавигдсан бүтээлүүд дээр би хувийн цуглуулгаасаа энэхүү “Байгалд туссан гэрэл” сэдэвт тохирох зарим бүтээлийг нэмж олон нийтэд зориулсан хэсэгт дэлгэн үзүүлж байна.

Энэхүү үзэсгэлэнд бас нэгэн этгээд гэмээр өнгө нэмж буй бүтээл бол Адди Соммек, Чарли Еккерт нарын дэлхий даяар аялж туурвисан уран бүтээлийнх нь нэг хэсэг болох “Бөмбөлөгөн малгайтай Монгол гэр бүл” зураг бөгөөд Америк хүн Монголд ирээд гоёмсог монгол малгайг бөмбөлөгөөр хэрхэн дүрсэлсэнийг харуулна. Энэ хоёр уран бүтээлч 34 орноор аялж, инээн баясч, хөгжилдөж байгаа хүмүүсийн зургийг авчээ. Тэдний хүсэл зорилго нь хүн бүр баяр баясгалан, инээд хөөртэй байх чадвартай төрсөн байдгийг харуулахад оршсон байна.

Үзэсгэлэнд тавигдсан бүх бүтээлүүд та бүхний таашаалд нийцнэ гэдэгт бид итгэж байна!

Пайпэр Энн Уинд Кэмбэлл
АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд

Улаанбаатар
2013 оны 10-р сар

“I began my career as a fine art photographer focused on the decisive moment and pursuing the magic of light. I looked for images that indicated a sense of universal wonderment and unity.

In my late twenties, I worked exclusively for conservation groups, photographing threatened habitats and endangered species around the world. I photographed so many different mammals in water habitats that water itself became a primary focus for my artistic endeavors. In the process of abstracting the qualities of water, as it transformed into its various aspects of light, color, movement, and energy, I began to experience a relationship with painting.

By 1983, painting had become my primary means of artistic expression and landscape painting became the primary focus of my work. My paintings are an expression of inspirations from nature and my relationship to the landscape. I strive to create harmony among the three forms of light available to an artist: surface light, the light of nature, and the light of spirit. My art is about presence and place.

I work in the landscape of Indiana, my home. Our roads, pastures, fields, and forests are the essence of our landscape, the American Midwest. The Indiana countryside is both simple and nourishing. It is in the basics of our landscape that one can see and feel the beauty of the essential, the elements of land and sky, of nature and humanity coming together. Rather than portraying the realism of a country scene, I am in pursuit of the experiential expression. When one stands alone in a field with grain and sky, wind and color as companions, an experience of unity can occur.

I am interested in expressing the harmony of the seen and the unseen. This experience of unity, which brings with it a sense of awe, supports and guides my work. My paintings are an attempt to honor the beauty and magic of living in our time and place.”

— John Domont

“Би анх уран зургийн фото зурагчнаар ажиллаж зураач болох гараагаа эхлэж байлаа. Ганц хормын агшинд гэрлийн тусгалыг өндөр мэдэрч, маш шийдэмгий бөгөөд хурдтай ажиллахыг шаарддаг ажил. Аль болох орчлон ертөнцийн нууцлагдмал гайхалтай, нэгдмэл шинж чанарыг өгүүлсэн бүтээлүүдийг сонирхдог байсан юм.

Хориод насандаа ерөнхийдөө байгаль хамгааллын багуудтай хамтран ажиллаж, дэлхийн дархан цаазат, устаж үгүй болох аюулд өртсөн байгаль, ургамал, ан амьтдын фото зураг авах ажил хийж байлаа. Тэр үед усанд амьдардаг маш олон төрлийн сүүн тэжээлт амьтдын зургийг авч байв. Тухайн үеийн ажлын туршлага маань намайг хожим нь зураач болоход, ялангуяа ус гэсэн сэдвээр илүүтэй дагнан уран бүтээлээ туурвихад хүчтэй нөлөөлсөн билээ. Зурагчин хүнийхээ хувьд усны төлөв байдал, гэрлээс ойж буй янз бүрийн тусгал, өнгө, хэлбэр дүрс, үйл хөдлөл, энэрги, эрч, хүчийг нь ялгаж салгах зуураа уран зурагтай холбон, хоорондын хамаарлыг нь ажиглан мэдэрсэн юм.

1983 он гэхэд уран зураг зурах, тэр дундаа байгалийн сэдэвтэй зураг зонхилж, зурах явдал миний хувьд урлагаар дамжуулан өөрийгөө илэрхийлэх гол зүйл хэдийнээ болчихсон байсан. Миний бүтээлүүд бол байгалийн гоо үзэсгэлэнгээс онгод авч, байгальтай тогтоож чадсан тэр харилцаанаас бүтсэн зурагнууд гэж хэлж болно. Би зураач хүнд байвал зохих гурван төрлийн гэрлийн тусгалууд, тэдгээрийн хоорондын зохицолдоог гаргахыг оролддог. Тэдгээр гэрлүүд нь гадаргуун дээр ойж буй гэрэл, байгалийн гэрэл, мөн тэнд бий болж буй оюун сэтгэлгээний гэрэл болно.

Би өөрийн төрсөн газар болох Индиана муж нутагт ажилладаг. Энэ нутгийн зам харгуй, уул хад, бэлчээр нутаг, газар тариалан, ой мод зэрэг нь Америкийн баруун-төв хэсгийн газар нутгийн онцлогийг харуулж чаддаг. Индианагийн хөдөө талын шимтэй хөрс, байгаль дэлхийн гайхалтай, үзэсгэлэнтэй зохилдлогоог эндээс харж мэдэрч болохуйц билээ. Би өөрийн бүтээлүүддээ хөдөө талын энгийн аж байдлыг дүрслэхээс гадна, яг тухайн орчинд байгаа хүнд ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байна, түүнийг илэрхийлэхийг хичээдэг билээ. Гав ганцаар хязгааргүй тэнгэрийн дор, амуу тариан уужим их талбайд, агаар салхи амсан, олон гэрэл, өнгийн тусгалтай нөхөрлөн зогсоход өөрийн эрхгүй өөрийгөө нэгэн агуу зүйлийн нэгээхэн хэсэг болсон мэт мэдэрдэг.

Тиймээс би аль болох эв нэгдэл, олон үзэгдэх, үл үзэгдэх хүчин зүйлүүдийн зохицлыг дүрслэхийг оролддог. Нэгэн агуу зүйлийн нэгээхэн хэсэг болж буйгаа мэдрэх тэр мэдрэмж маш их сэтгэл догдлол, гайхшрал, уран бүтээлээ хийх эрч хүч, урам зоригийг өгч байдаг. Миний бүтээлүүд бол өөрийн амьдарч буй цаг мөч, оршин буй байгаль дэлхийн ид шидийн юм шиг гоо үзэмжийг магтан дуулж, алдаршуулахад гаргасан хүчин чармайлтын минь үр шим юм.”

— Жон Домонт

John Domont | 1950

Born in Indianapolis, Indiana, in 1950, John Domont holds a Bachelor of Fine Arts degree from the California College of Art. He has traveled extensively and has lived in California, New Mexico, France, Germany, and Israel. The recipient of several artists' awards and commissions, he currently lives and works in Indianapolis. His art has been shown in numerous exhibitions and is in the collections of the Indiana State Museum, the National Bank of Indianapolis, and the Indiana Historical Society, all in Indianapolis; the Swope Museum, Terre Haute, Indiana; the Norton Simon Museum, Pasadena, California; as well as in many private collections.

www.domontgallery.com

Жон Домонт | 1950

Жон Домонт 1950 онд Индиана мужийн Индианаполис хотод төржээ. Калифорнийн Дүрслэх Урлагийн Коллежийг Уран Зургийн Баклавр зэрэгтэй төгссөн ба олон газраар аялан ажиллаж байсан байна /Калифорни, Шинэ Мексик, Франц, Израиль гэх мэт/. Уран бүтээлчийнхээ хувьд нэртэй олон шагнал авч байсан бөгөөд одоогоор төрсөн нутаг Индианаполисдоо оршин суун ажиллаж байгаа билээ. Түүний бүтээл, коллекцууд Индиана мужийн Музей, Индианаполис хотын Үндэсний Банк, мөн Индиана мужийн Түүхийн Нийгэмлэг гэх мэт тус муж, хотын томоохон газруудад зохион байгуулагдсан олон тооны үзэсгэлэнд тавигдаж байсан аж. Үүнээс гадна түүний бүтээлүүд болон хувийн коллекцууд нь Индиана мужийн бусад хотуудад байдаг Суопь Музей, Терре Оуть, мөн Калифорния мужийн Пасадена хотын Нортон Саймон музей гэх мэт газруудад олны хүртээл болж байжээ.

www.domontgallery.com



Heartland Haiku 106, 2013

Acrylic on canvas, 40 x 66 in. Courtesy of the artist, Indianapolis, Indiana

Хартландын Хайку 106, 2013

Акрилийн зотон дээр бүтээсэн, 101,6 x 167,6 см. Зураачийн зөвшөөрөл олгогдсон, Индианаполис хот, Индиана муж

Charlie Eckert | 1969

“I feel as if I have gone a thousand years back in time as I watch the two Mongolian horsemen race past our Russian jeep. They stand in the stirrups of their wooden saddles, the setting sun shining off their silk dells, their squat horses with thick coats kicking up snow as they pass us. It is easy to imagine these horsemen following Ghengis Khan all the way to Europe 700 years ago.

‘Hold back the dogs!’ is how the Mongolian greeting translates into English. By the look of them, ‘Hold back the wolves’ is more appropriate. It is tradition in Mongolia to take in strangers – a good policy when the average winter night is 30 below.

As guests we learn about Mongolian etiquette: When entering a ger, the tent-like structure of these nomadic people, men must go to the right, women to the left. You must immediately shake hands with anyone if you step on his foot. You show respect to your host’s shrine by not turning your back towards it. And most importantly, since they do not have much, you learn to accept everything your host offers you.”

— Charlie Eckert

In 1996, balloon artist Addi Somekh and photographer Charlie Eckert began their travels to the most diverse places of the world to make balloon hats for the people there and to take photos of them. Their aim was to photograph people all over the world laughing and having fun. They wished to emphasize the fact that all people are born with the ability to experience enjoyment. They visited a total of thirty-four countries and took over 10,000 photographs. Born in Hollywood, California, in 1972, Somekh also plays the balloon bass in the Los Angeles-based band *Unpopable*, along with Henry Bermudez on guitar. While attending graduate school at the New School for Social Research, New York, he met Queens, New York native and amateur-photographer Charlie Eckert in 1995.

www.balloonhat.com

Чарли Еккерт | 1969

“Тэр үед Орос жийпэнд суугаад жирийлгэж явахад хажуугаар морьтой хоёр Монгол залуу давхин өнгөрөх тэр агшин өөрийн эрхгүй мянган жилийн өмнөх цаг үед очсон мэт санагдаж билээ. Тэд модон эмээл дээрээ тухлан суугаад, жаргаж буй нарны туяа торгон дээлэн дээр нь гялалзан тусаж, морьд нь цасан дундуур цагаан тоос бужигнуулан өнгөрөн гарсансан. Тэдгээр залуусыг 700 жилийн тэртээх Чингис хааны тушаалаар алс холын Европын зүг яг чингээд давхин одож буйгаар төсөөлөхөд ихээхэн бодитой мэт санагдаж билээ.

Монголчууд хоорондоо мэнд мэдэх ёс нь ‘Нохойгоо хорь оо!’ гэхээс эхлэнэ. Нохойных нь дүр төрхийг ажвал, ‘Чоно оо хорь оо!’ гэх нь илүү тохиромжтой мэт санагдана. Гадны хүнийг уриалгаханаар хүлээж авах нь Монгол ёс заншил.

Бид гадны зочид байсан учир Монголын бүхий л энгийн зан үйлд суралцсан билээ. Тухайлбал нүүдэлчдийн амьдардаг уламжлалт Гэрт нь орохдоо аливаа зочин эрэгтэй бол гэрийн баруун тал руу, эмэгтэй бол зүүн тал руу нь чиглэн явж тухлах ёстой байдаг. Хэн нэгний хөл дээр гишгэсэн бол гар барина. Бурхан шүтээнийг нь хүндэтгэх ёстой бөгөөд хэн нэгэн рүү нуруугаа харуулж сууж болохгүй. Мөн хамгийн чухал нь таныг хүлээн авч байгаа айл таньд гэж санал болгож байгаа ямар ч зүйлийг хүлээн авах хэрэг юм, учир нь угаасаа байгаа нөхцөлд хамгийн сайныг нь таньд буюу зочиндоо зориулж байгааг та ойлгож авдаг.”

— Чарли Еккерт

1996 оноос хойш шаараар урладаг Адди Соммек болон фото зурагчин Чарли Еккерт нар хамтран дэлхийн хамгийн содон, өвөрмөц газруудаар аялан, нутгийн уугуул иргэдтэй уулзан шааран малгай урлан өмсгөөд зураг авдаг уран бүтээлчид болсон юм. Тэдний гол зорилго нь хүмүүст инээд хөөр бэлэглэж, хөгжил баяртай зураг авах явдал. Тэд энэ төслөө хэрэгжүүлсэнээрээ хүн бүр инээж хөгжин баярлаж чаддагаараа ижил юм гэдгийг тодотгон харуулахыг эрмэлзсэн юм. Тэд хамтдаа 34 улсаар аялж, 10,000 гаруй фото зураг авсан байна. 1972 онд Калифорни мужийн Голливудад төрсөн Соммек шааран басс хөгжим тоглодог ба Лос Анжелесийн Unpopable буюу Хагардаггүй Шаар хамтлагт гитарчин Генри Бермудезтэй цуг тоглодог ажээ. Тэрээр 1995 оны үед Нью Йорк хотноо Нийгэм Судлалын Шинэ Их Сургуульд дээд боловсролын зэргээ хамгаалахаар суралцаж байхдаа Нью Йорк-ын Күйинс хотын уугуул, залуу фото зурагчин Чарли Еккерттэй танилцсан байна.

www.balloonhat.com



Mongolian Family with Balloon Hats, 1997

Color photograph, 24 x 31 in. Courtesy of Addi Somekh and Charlie Eckert, New York, New York

Бөмбөлөгөн малгайтай Монгол гэр бүл, 1997

Адди Соммек болон Чарли Еккерт нарын зөвшөөрөл олгогдсон, Нью Йорк хот, Нью Йорк муж

Jo Fleming | 1969

“For me painting is a way of contemplating the natural world and my relationship to it. I was born in the Appalachian Mountains of Virginia, a pristine environment threatened by coal removal. My family migrated to Northern Virginia, near Washington, D.C. I studied art and received a Bachelor of Fine Arts degree from the Maryland Institute College of Art, in Baltimore.

Variations of form and color, patterns of growth and the relationship of the natural environment impacted by human activity are the inspiration for my paintings. I am fascinated by the ever-increasing presence of the man-made component in the rural landscape as well as the vital importance of the natural element in the urban setting. My paintings are compositions about the intersection of the two worlds.

My instinct to express nature at full size has led me to a modular approach, incorporating print and mixed media materials into my paintings. My work has been shown regionally in solo exhibitions and is placed in private as well as commercial collections.”

— Jo Fleming

Jo Fleming lives and paints in Great Falls, Virginia. As well as having studied at the Maryland Institute College of Art, she has also studied at American University in Washington, D.C., and taught in the art department at Montgomery College, Maryland.

Жөү Флеминг | 1969

“Миний хувьд зураг зурахыг байгаль орчинтой харьцаж, өөр хоорондын уялдаа холбоо харилцааг тунгаан шүүх нэг арга гэж үздэг. Миний бие Виржиния мужын Аппалачийн нуруудын ойролцоо төрсөн. Уг газар нь үзэсгэлэн төгөлдөр авч нүүрс олборлолтын бай болсоныг хэлмээр байна. Манай гэр бүл Умард Виржиниягийн ойролцоо нүүж Вашингтон ДС хоттой улам ойртсон юм. Би Мэрилэнд мужийн Балтимор хот дахь Мэрилэндын Их Сургуулийн Уран Зургийн Коллежээс Дүрслэх Урлагийн Баклавр зэргээ авсан.

Өнгө, дүрслэлийн ялгаа, өөрчлөлт, мөн байгаль орчны тогтолцоо тэр тусмаа хүний нөлөөнд автагдсан дүр төрх миний уран бүтээлийн гол сэдэв болж, надад шинэлэг сэтгэлгээ, уран бүтээлийн их онгодыг өгч байдаг. Хот хөдөөгийн байгаль, дүр төрх хэрхэн цагийн эрхээр хүний нөлөөнд орж, өөрчлөгдөж байгааг ажиглаж, сэтгэл минь ихэд хөдөлж, уран бүтээлүүд минь хөглөгдөж байдаг. Тиймээс ч миний бүтээсэн бүтээлүүд бол хоёр өөр ертөнц хэрхэн нийлж, оршин тогтнож байгааг өгүүлдэг.

Бодитой оршин байгаа байгаль дэлхийг бүхэлд нь тэр чигээр нь илэрхийлэх хүсэл эрмэлзэлийн дор тэр бүхнээс хэсэгчлэн урлаж бүтээлүүдээ техникийн төрөл төрлийн хэлбэрүүдийг ашиглан гаргах болсон. Өөрийн бүтээсэн ажлуудаараа бүс нутгийн хэмжээнд болж байсан хэд хэдэн арга хэмжээнүүдэд бие даан оролцож байснаас гадна хувийн болон худалдааны коллекциудад орж байлаа.”

— Жөү Флеминг

Жөү Флеминг Виржиния мужийн Грейт Уоллс хотод ажиллаж амьдардаг бөгөөд Мэрилэндын Институтын Уран Зургийн Коллежийг дүүргэсэнээс гадна Вашингтон ДС хотын Америкийн Их Сургуульд мөн суралцаж, Мэрилэнд мужийн Монтгомери коллежийн уран зургийн тэнхимд багшаар ажиллаж байсан юм.

Jo Fleming | Жөү Флеминг



Meadow, 2012

Mixed media on canvas, Diptych, each panel: 36 x 24 in.

Courtesy of the artist, Great Falls, Virginia

Нура, 2012

Зотон дээрх холимог техник, Дэлгэцтэй самбар: дэлгэц тус бүр нь 91,4 x 61 см

Уран бүтээлчийн зөвшөөрөл олгогдсон, Грейт Уоллс хот, Виржиния муж

Jo Fleming | Жөү Флеминг



Earth Meets Sky, 2012

Mixed media on canvas, 16 x 24 in.
Courtesy of the artist, Great Falls, Virginia

Тэнгэр газрын зааг, 2012

Зотон дээрх холимог техник, 40,6 x 61 см
Уран бүтээлчийн зөвшөөрөл олгогдсон, Грейт Уоллс хот, Виржиния муж

Jo Fleming | Жөү Флеминг



Ozone Layer, 2008

Acrylic and mixed media on canvas, Diptych: 60 x 32 in.
Courtesy of the artist, Great Falls, Virginia

Озоны давхрага, 2008

Зотон дээрх акрил ба холимог техник, Дэлгэцтэй самбар: 152,4 x 81,3 см
Уран бүтээлчийн зөвшөөрөл олгогдсон, Грейт Уоллс хот, Виржиния муж

Julian Jackson | 1953

“In the year 1073, painter and theorist Kuo Hsi asked, ‘Why do people love landscape?’ and answered, ‘Hills and gardens restore our nature (chi), so we should visit them often.’”

Painting for me has always been a means of approaching and understanding the natural world, both as we find it and how we apprehend and reconfigure it. The rational construct of the framing rectangle provides limitless interpretive space in which to experience multiple realities. I am particularly interested in creating work with the power to suggest experience rather than define it, where engagement is, in a sense, physical and one enters the painting as one might enter a forest or take the first step on a path.

I think of paintings as places that one can revisit often as one would a favorite mountain, tree, garden, or building.

The elusive nature of light has been my subject now for more than ten years and I have come to embrace this ephemerality with its attendant ambiguities as the core of my painting practice.

In my paintings, composed structures provide a toehold in wozy space while colors shift and spill from their indeterminate boundaries like changing moods.

The work finds its grounding in the fundamental opposition of the vertical to the horizontal axis. My compositions appear nearly as solid as architecture when viewed from a distance but upon closer inspection their ambiguous space reveals itself as the layers and shapes soften and shift. Spatially nothing within these complex structures is set and there is an appearance of constant and subtle motion. Working with layers of thin oil glazes, I brush the paint surface out until it is completely softened and nearly devoid of brush strokes. In this way, I dematerialize the substance of paint, covering the tracks of process to present a tangible experience of color that is closer to its source: light.

Light, color, and a sense of complex layered space are the central themes of my work.”

— Julian Jackson

Жулиян Жексон | 1953

“1073 онд зураач, онолч Кюө Хси ‘хүмүүс бид яагаад байгаль дэлхийн гоо үзэсгэлэнт байдалд дурладаг юм бол?’ гэсэн асуултад ‘уул нурууд, цэцэгт хөндий ба хүрээлэн буй орчин нь бидний байгалаас заяасан зан чанарыг (чи) сэргээн суулгаж өгдөг учраас бид аль болох тэр орчинд ойр байж, олонтаа эргэн очиж байх ёстой юм’ гэж хариулсан байдаг.

Уран зураг бол миний хувьд хүрээлэн буй орчноо байгаагаар нь хүлээн авч, өөрсдийн бодол сэтгэлээсээ ургуулан урлан бодох нөхцөлийг бүрдүүлдэг зүйл билээ. Утга төгөлдөр тэгш дөрвөлжин талбай нь хэд хэдэн бодит байдлыг тусгах хязгааргүй боломж орон зайг өгнө. Би өөрийн бүтээлээ аль болох шууд нэгэн утга санаа илэрхийлэхээс илүүтэй, шинэ мэдрэмж төрүүлж, үзэгчийг бүтээлдээ татан оруулах, өөрөөр хэлвэл ой модны зураг байлаа гэж бодоход яг л бодитоор ойн модонд анхны алхамаа тэнд буй жимээр хийж байна гэж мэдрэхээр зурахыг хичээдэг.

Би уран зургийн бүтээлүүдийг тус бүрт нь өөр өөр газар нутаг устай зүйрлэн боддог. Хүнд очих дуртай уул ус, цэцэгт тал, байшин барилга гэж байдаг шиг уран зургууд ч мөн адил хэн нэгний эргэн очих дуртай газар нь болдог байх.

Гэрлийн гарт үл баригдам, нууцлагдмал, биширмээр шинж чанар сүүлийн арван жилийн турш миний уран бүтээлийн гол сэдэв нь байсаар ирсэн.

Зургуудынхаа сууринд аль болох энгийн тогтсон, бага зэрэг манантсан уур амьсгал өгөхийг хичээдэг. Дээрээс нь өөр өөр, санаандгүй гэмээр өнгө зурвасуудыг оруулж яг л сэтгэл хөдлөл шиг зургийн өрнөлийг өөрчлөн орон зайг тэлж өгдөг.

Миний зурагнуудын гол суурь агуулга нь тэр чигээрээ уртраг өргөрөг, эсрэг тэсрэг хоёр туйл огтлолцож байгаа мэтээр бүтдэг. Холоос харахад зураг маань яг л биетэй жинхэнэ юм шиг харагддаг. Харин ойроос сайтар ажиглавал тодорхой бус олон судал татлууд илүү бүдэг зөөлрөн харагдаж, өөрчлөгдөж байгаа юм шиг санагдуулдаг. Орон зайн үүднээс хэлэхэд, зурган дахь дүрс дүрслэл харагдах байдал нь хэзээ ч нэг янзаараа биш, байнгын хөдөлгөөнд буй мэт байдаг. Давхар давхар тосон өнгө будаг хэрэглэж бүтээлээ хийдэг ч, дуусахынхаа өмнө зургийн гадаргуу маань өв тэгш, овгор товгор зүйлгүй байгааг шалгадаг. Бийр бэхний ор мөр огт байх ёсгүй. Зөвхөн үүний дараа л бүтээлээсээ өнгө будаг гэсэн ухагдахууныг нь тэр чигээр нь алга хийж, ямар үйл ажиллагаа орсон талаарх ул мөрийг арилгаж, бүтээл маань бүтсэн анхдагч эх үүсвэрийг тусгахыг хичээдэг, тэр маань мэдээж “гэрэл” шүү дээ.

Julian Jackson | 1953

Julian Jackson was born in Richmond, Virginia, and lives and works in Brooklyn, New York. He studied painting, printmaking, photography, and performance at Massachusetts College of Art, Boston, and received a Bachelor of Fine Arts degree from Virginia Commonwealth University, Richmond. The recipient of several awards and fellowships, he has participated in shows throughout the United States, as well as in Austria, Germany, Italy, The Netherlands, and Turkey. His work can be found in numerous private and public collections.

www.julianjacksonstudio.com

Жулиян Жексон | 1953

Гэрэл, өнгө, болон давхар давхар орон зайнууд нь миний ажлын гол онцлог шинж чанарууд юм.”

— Жулиян Жексон

Жулиян Жексон Виржиния мужийн Ричмонд хотод төрсөн, Нью Йорк хотын Бруклин дүүрэгт амьдардаг аж. Тэрээр Бостон дахь Массачусеттсийн Урлагийн коллежид дүрслэх урлаг, хэвлэл, фото зураг болон урлагийн тоглолт зэрэг чиглэлээр суралцсан ба Дүрслэх урлагийн Баклавр зэргээ Ричмонд дахь Виржиниягийн Хамтын Нийгэмлэгийн Их Сургуулиас авсан байна. Уран бүтээлч маань хэд хэдэн шагнал өргөмжлөлийн эзэн бөгөөд олон байгууллага, институтын хүндтэй гишүүн ажээ. АНУ болон, Австри, Герман, Итали, Нидерланд, Турк улсуудад бүтээлээ толилуулж байсан. Түүний уран зураг, бүтээлүүдийг олон нийтийн болон хувийн олон олон байгууллагуудын цуглуулагуудаас олж үзэж болно.

www.julianjacksonstudio.com

Julian Jackson | Жулиян Жексон



July 1, 2011. Oil on panel, 28 x 26 in. Courtesy of the artist and Page Bond Gallery, Richmond, Virginia

7 дугаар сарын 1, 2011. Тосон зураг, 71,1 x 66 см. Уран бүтээлчийн болон Пейж Бонд Галлерейн зөвшөөрөл олгогдсон, Ричмонд хот, Виржиния муж

Stephen Pentak | 1951

"It's really important to me that the person seeing the painting is simultaneously aware of the landscape and the marks that went into making it. One minute, they're suckered into the landscape, and then they're brought back to the surface because they see the marks. By noticing each mark, they recognize this is a construction, not a window into another world. Through that, you recognize in your response to the landscape that how we feel we fit into the natural world is also a constructed story we tell ourselves. It asks you to think about another level of recognition. That's one of the reasons I've never been a figure painter. The implicit figure is always the viewer." *

Inspired by nature, Stephen Pentak paints from memory in his studio. Wielding an array of brushes and palette knives, he applies and scrapes down pigment in an extended process. Typically he begins with a yellow ground, and from there, chooses colors to suggest atmospheric qualities, among other effects.

Born in Colorado, Stephen Pentak received his Bachelor of Arts degree from Union College in Schenectady, New York, and his Master of Fine Art degree from Tyler School of Art at Temple University, Philadelphia, Pennsylvania. He is Professor Emeritus of Art, and a past Associate Dean of the College of the Arts at Ohio State University, Columbus. He has been the recipient of four Ohio Arts Council Fellowships and he has been a visiting resident artist at Delfina Studios in London, and Glasgow School of Art, Scotland. In 2007 Pentak taught in Cortona, Italy, at the University of Georgia Program. He is co-author of *Color Basics* and *Design Basics* published by Wadsworth.

Pentak's recent solo exhibitions include shows at Kathryn Markel Fine Arts in New York City and Susan Street Fine Art in San Diego, California. Important group exhibitions include The 25th Anniversary Exhibition at The Drawing Center in New York City. His work is in numerous public and private collections, including the Columbus Museum of Art, Ohio, and the Wexner Center for the Arts, Ohio State University.

Pentak now has his home and studio in the Hudson Valley of New York with his wife Deborah.

<http://stephenpentak.com/StephenPentak/Biography.html>

* <http://www.kenygalleries.com/images/ac-pentakstephen/ac-pentakstephen2/PentakCitysceneJuly10.html>

Стефан Пентак | 1951

"Миний бодлоор, уран зураг үзэж байгаа хүнд бүтээлийн гол сэдэв, зураг урласан байдал аль аль нь харагдаж мэдрэгдэж байх нь чухал. Бүтээлийг нэг өнцөгөөс харахад зураг доторх байгаль, уул усанд очсон мэт санагдаад, харин зургийн өнгө будгийг олж харан ажаад зургийн гадаргуун дээр эргэн ирсэн мэт болдог. Өнгө будгийн ажилбарыг нэг бүрчлэн хараад өөр ертөнц рүү дагуулах зүйл биш харин зургийг хүний гараар бүтсэн, хэрхэн яаж бүтсэн гэдгийг олж харна. Ингэснээр байгаль дэлхийтэй өөрсдийгөө хэрхэн холбогдож буйг олж мэдрэх нь бүтээл хэрхэн болсныг илтгэнэ. Зурагнууд маань үзэгчдээсээ арай өөр түвшинд бодож сэтгэхийг шаарддаг. Тиймээс би хэзээ ч ямар нэгэн дүр, дүрслэл, хэлбэрт автагдаж байгаагүй. Бүтээлүүдийн маань салшгүй хэсэг нь үзэгч өөрөө юм." *

Стефан Пентак байгаль дэлхийн унаган төрх, төлөв байдлаас онгодоо авч өөрийн сэтгэлд буй дүрслэлээ зурагт буулгадаг. Өнгө өнгийн багс, бийр, будгийн хэрэгслэл, бусад тоног төхөөрөмж гэх мэт зүйлсийг ашиглан пигментүүдээ ийш тийш урт урт татлан зурна. Ихэнх тохилдолд тэр шар өнгөөр эхлээд суурийг нь өнгөлөөд, дээрээс нь орчин нөхцөлийн онцлог шинж чанаруудыг гаргасан өнгө будаг нэмэн баяжуулдаг.

Тэрээр Колорадо мужид төрсөн бөгөөд соёл урлагийн чиглэлээр Нью Йорк хотын Шенектеди дүүрэгт Юнион коллежоос Баклавр зэргээ авч, Пеннсилвани мужийн Филадельфия хотод байрлах Дүрслэх урлагийн Темпел их сургуулийн Тайлор сургуульд Магистрийн зэргээ хамгаалж мэргэжил дээшлүүлсэн байна. Одоогоор Колумб хотын Охояогийн их сургуулийн Дүрслэх урлагийн тэнхимийн хүндэт багш бөгөөд урьд нь уг тэнхимийн захиралаар нь ажиллаж байсан ажээ. Тэрээр Охаяо мужийн Урлагийн зөвлөлийн гишүүнээр дөрвөн удаа сонгогдож байсан ба зураач зочиноор Лондонгийн Делфинийн студи, Шотландын урлагийн Гласкоу сургууль зэрэг газруудтай хамтран ажилласаар байна. 2007 онд Италийн Кортон хотод Гиоргийн их сургуулийн програмаар дамжуулан очиж хичээл зааж байсан. Өнгө Будагны Үндэс болон Загвар Дизайн Гаргах Үндэс гэсэн номнуудыг мөн Вадсворттой хамтран бичсэн зохиогч нь юм.


Пентакийн сүүлд бие даан гаргасан үзэсгэлэнгүүд нь Нью Йорк хотын Кетрин Марделийн галлерей болон Калифорни мужийн Сан Диего хот дахь Сюзан Стрийтийн галлерей гэх мэт газруудад алдаршсан билээ. Олон уран бүтээлчдийг хамарсан томоохон үзэсгэлэн Нью Йорк хотын Уран зургийн төвийн 25 жилийн ойгоор гарсан бөгөөд Пентак мөн л бүтээлээрээ оролцсон аж. Түүний уран бүтээлүүд олон нийт ба хувийн байгууллагуудаар тавигдаж байсан жишээ дурьдвал: Охаяо мужийн Колумбын дүрслэх урлагийн музей, Охаяогийн их сургуулийн дүрслэх урлагийн Векснер төв зэрэг орно.

Эдүгээ Пентак уран бүтээлээ гэрийн студид туурьваж байгаа бөгөөд Нью Йорк хотын Хадсон Валий дүүрэгт эхнэр Дебратайгаа амьдарч байна.

<http://stephenpentak.com/StephenPentak/Biography.html>

* <http://www.kenygalleries.com/images/ac-pentakstephen/ac-pentakstephen2/PentakCitysceneJuly10.html>

Stephen Pentak | Стефан Пентак



4.2, 2011. Oil on panel, 22 x 30 in. Courtesy of the artist and Kathryn Markel Fine Arts, New York, New York

4.2, 2011. Тосон зураг, 55,9 x 76,2 см. Уран бүтээлчийн болон Кетрин Марделийн Галлерейн зөвшөөрөл олгогдсон, Нью Йорк хот, Нью Йорк муж

John Torina | 1953

John Torina began traveling in his teens: playing in a band, he tasted international travel and loved it. In his early twenties, he decided he needed a career and decided that he'd be an artist. In the ensuing thirty years, Torina has camped and painted in many states throughout the United States, as well as secluded spots in Mexico, Costa Rica, New Zealand, Israel, Norway – just to name a few far-flung outposts. Torina paints on site. He sets up his canvas on the tailgate of his truck, paints until the light is gone, and often visits the same site for days at a time. His goal is to understand not just the scene, but also the place and its unique locus in the environment. The only real studio time a painting receives is the inspection prior to varnish when he removes the bits of sand, grass, sticks or bugs that have been trapped in the wet paint.

Torina's perception of nature is spiritual with a purist's point of view. "When I observe nature I try to catch its raw tension. It's not conceptualized, it is more experiential." This direct confrontation elevates a mundane landscape to depiction of the primal essence of the universe. In the *Memphis Commercial Appeal*, reviewer Fredric Koeppl wrote: "Torina's proficiency has attained near mystical levels. He inhabits the realm of landscape and sky, lent weight and substance by the action of pigment, the intensity of vision and the evocative depths of shadow."

Torina was born in Memphis, Tennessee. He studied at the University of Memphis, later earning a Bachelor of Fine Arts degree from Memphis College of Art and a Master of Fine Arts degree from the University of Oregon, Eugene. Over the years, his work has been featured in numerous exhibitions across the United States, and has also been included in private and public collections.

www.davidluskgallery.com

Жон Торина | 1953

Жон Торина өсвөр наснаасаа л аялаж эхэлсэн. Тэрээр хамтлагт хөгжим тоглодог байсан бөгөөд бага залуугаасаа олон улс орноор явж, гадаад дотоодоор аялах дуртай болсон байна. Хориод насандаа аливаа хүнд өөрт нь тогтсон мэргэжил ямар чухал хэрэгтэйг ойлгоод Торина улмаар зураач болохоор шийдсэн ажээ. Торина 30-аад насандаа АНУ-ын олон муж, хотуудаар аялахаас гадна Мексик, Коста Рика, Шинэ Зеланд, Израиль, Норвеги зэрэг хол ойрын олон улс орнуудын эзгүй хээр тал, байгалийн үзэсгэлэнт газруудаар явж өөрийн уран бүтээлээ бий болгосон байна. Түүний зураг, бүтээлүүдийн гол зорилго ба мөн чанар нь зүгээр тухайн нөхцөлд оршиж байгаа үзэгдлийг ойлгох биш, тухайн газар, нутаг ус, түүний онцлог шинж чанаруудыг сайтар ойлгохыг эрмэлздэг аж. Түүний бүтээл, уран зургууд мэргэжлийн студийн арчилгаа авдаг ховор тохиолдол нь зургаа зурахын өмнө зураач тос будганд наалдсан элдэв хорхой шавж, элс, шороо, модны үртэс зэргийг цэвэрлэж буй зөвхөн тэр л агшин байдаг аж.

Торинагийн байгаль дэлхийн тухай үзэл баримтлал бол спиричуел бөгөөд пурист сэтгэлгээний шинж чанартай юм: "би байгалийн онцлог шинж чанар ба байгаа байдлыг ажиглахдаа аль болох байгаль дээр буй зохилдлогоо буюу зөрчлийг олж харахыг хичээдэг. Ямар нэгэн ухагдахуун ойлголт илэрхийлэхээс илүүтэйгээр тухайн үеийн ажиглалт, бодит байдалтай нийцүүлж тусгахыг оролддог." Иймэрхүү шууд тусгал нь зүгээр л оршин буй байгалийн энгийн нэгэн зураглалыг хорвоо ертөнцийн нэгээхэн хэсэг болгон харуулахад хүрдэг байна. Мемфис хотын өдрийн Коммерсиал Апгийл сонингийн редактор Фредерик Коэппел ийнхүү бичиж байжээ: "Торинагийн ур чадвар нууцлаг ертөнцийг өгүүлж байдаг. Тэрээр газар тэнгэрийн хоорондох хязгааргүй орон зайд бүтээлээ бий болгодог ба пигмент татлах болон өөрийн хурц ажиглалт хийх, гэрэл сүүдрийн ялгааг тод дүрсэлж чадсанаараа эд зүйлс, даралт болон жингийн нөлөөг тус бүрээр нь алга болгодог," гэжээ.

Торина Теннессий мужийн Мемфис хотноо төрсөн ба Мемфисийн их сургуульд суралцаж, Мемфисийн дүрслэх урлагийн коллежоос Баклаврын зэрэг авч, Орегон мужийн Южинь хотод байрлах Орегоны их сургуулиас дүрслэх урлагийн Магистерийн зэрэг хүртсэн байна. Түүний бүтээлүүд жилээс жилд АНУ-ын олон уран зургийн галлерейн үзэсгэлэнд тавигдсаар ирсэн ба хувийн болон олон нийтийн коллекц-д Торина өөрийн бүтээлээрээ идэвхитэй оролцдог байна.

www.davidluskgallery.com

John Torina | Жон Торина



Atlantic Coast, 2012. Oil on canvas, 48 x 48 in. Courtesy of the artist and David Lusk Gallery, Memphis, Tennessee
Атлантын эрэг, 2012. Тосон зураг, 121,9 x 121,9 см. Уран бүтээлчийн болон Девид Луск Галлерейн зөвшөөрөл олгогдсон, Мемфис хот, Теннесси муж

Robert Yasuda | 1940

“The quiet complexity of form and meaning are a trademark of [Robert] Yasuda’s signature paintings. They are meditative paintings, which create a depth of space that allows the viewer to visually move within the painting itself.

The paintings are not static. The slow revelation of the true nature of the paintings is brought about by their relationship to various light sources, so the paintings remain active in their relationship to changes in day and night and to the viewers’ movements and ever changing eye. Yasuda’s paintings are painted on wood, sometimes multi-paneled, which are often carved, shaped, and modified to enhance the physical presence of the image, and then covered with very fine fabric, many transparent and translucent layers of mediums and pigments applied to make up the final color, then varnishes creating a very light active surface.”

— Michael Brennan

Born in Hawaii, Robert Yasuda moved to New York City in the late 1950s, where he continues to live and work. He received a Bachelor of Arts degree and a Master of Fine Art degree from Pratt Institute, New York. He has taught at Long Island University, C.W. Post Center, Greenvale, and at the New York Institute of Technology, Westbury, both in New York. The recipient of several awards, including a grant from the National Endowment for the Arts, Yasuda has participated in exhibitions in the United States, as well as in Germany, Italy, and Switzerland. His work can be found in the collections of The Library of Congress, Washington, D.C.; the Brooklyn Museum, New York; the Wadsworth Athenaeum, Hartford, Connecticut; the Bass Museum, Miami Florida; the Carnegie Institute, Pittsburg, Pennsylvania; and many others.

www.davidluskgallery.com
www.robertyasuda.com

Роберт Ясуда | 1940

“Роберт Ясудагийн алдарт бүтээлүүд хэлбэр дүрслэлийн намуун дөlgөөн байдал, өөр хоорондын нийцэл, зохицол зэргээрээ бусдаас ялгарч тэдгээр нь ч түүнийг таниулах гол таних тэмдэг болдог байна. Түүний уран зургууд бясалгалын бүтээлүүд байдаг. Уран зураг сонирхогч нэгэнд зурган дотор нь орж, өөрийнхөөрөө чөлөөтэй сэтгэж мэдрэх тэр орон зайг өгч чаддаг байна.

Түүний уран зургууд нэг янзаараа байдаггүй. Харин зургуудын мөн чанар нь өглөөнөөс орой үдэш хүртэл солигдох гэрлийн олон янзын тусгал, үзэгчийн бүтээлийг харж буй орон зай, үргэлж хөдлөх нүдний хараанаас хамаараад зураг өөрчлөгдөн хөдөлгөөнд оршино. Ясудагийн бүтээлүүд бол модон гадаргуун дээр бүтээгдсэн байдаг ба заримдаа үргэлжилсэн, хэд хэдэн гадаргуун дээр бүтээсэн мэт зургууд байдаг. Тэдгээр гадаргуунууд нь гол төлөв хэлбэрт оруулсан, сийлбэрлэсэн, эмтэлж, өөрчилсөн байдаг. Тэгснээрээ зурагныхаа бодит дүрслэлийг гаргаж өгдөг ба түүнийгээ их нарийн хийц материалтай даавуугаар бүрхэж давхар давхар гэрэлтдэг, нэвт харагддаг гадаргуу нэмж хамгийн эцсийн өнгийг бүтээдэг. Түүний дээр өнгө будаг нэмж бүтээлээ хөдөлгөөнд оруулж, гадаргууг их хөнгөхөн гэхдээ сонирхолтой болгож өгдөг ажээ.”

— Майкел Бреннан

Роберт Ясуда нь Гавай мужид төрсөн бөгөөд 1950-иад оны сүүлээр Нью Йорк хот руу нүүж өнөөг хүртэл ажиллаж амьдарч ирсэн байна. Тэрээр дүрслэх урлагаар дагнан суралцаж Баклавр болон Магистрийн зэргээ Нью Йорк хотын Пратт Институтаас авчээ. Лонг Айланд их сургууль, С.В. Пост Центр, Грийнвилд багшаар ажиллаж байсан ба Уестбүри дахь Нью Йоркийн Техникийн институтэд мөн ажиллаж байсан байна. Зураач маань хэд хэдэн шагналын эзэн бөгөөд Үндэсний дүрслэх урлагийн сангаас грант тэтгэлэг авч байсан. Тэрээр АНУ төдийгүй Герман, Итали, Швейцарь улс орнуудаар үзэсгэлэнд оролцож байсан ба түүний бүтээлүүд Вашингтон ДС дахь АНУ-ын Конгрессийн Номын Сан, Нью Йорк хотын Вруклиний музей, Коннектиккат мужын Хартфорд дахь Уадсуортын уран зургийн музей, Флорида мужийн Миами дахь Басс музей, Пеннсилвани мужийн Питтсбург хот дахь Карнеги институт гэх мэт олон газруудад хадгалагдаж байдаг.

www.davidluskgallery.com
www.robertyasuda.com

Robert Yasuda | Роберт Ясуда



Overlook, 2011. Acrylic polymer on fabric on wood, 38 x 83 x 2 ¼ in.
Courtesy of the artist and David Lusk Gallery, Memphis, Tennessee

Үл анзаар, 2011. Даавуун бүрээстэй Модон дээр тавьсан Акрил полимер, 96,5 x 210,8 x 5,7 см
Уран бүтээлчийн болон Девид Луск Галлерейн зөвшөөрөл олгогдсон, Мемфис хот, Теннесси муж

Robert Yasuda | Роберт Ясуда



Pacific, 2011. Acrylic polymer on fabric on wood, 57 x 49 x 2 ¼ in.
Courtesy of the artist and David Lusk Gallery, Memphis, Tennessee

Номхон, 2011. Даавуун бүрээстэй Модон дээрх Акрил полимер, 144,8 x 124,5 x 5,7 см
Уран бүтээлчийн болон Дэвид Луск Галлерейн зөвшөөрөл олгосон, Мемфис хот, Теннесси муж

ACKNOWLEDGMENTS

Washington, D.C.

Sarah Tanguy, Curator
Theresa Beall, Registrar
Marcia Mayo, Senior Editor
Sally Mansfield, Editor
Amanda Brooks, Imaging Manager

U.S. Embassy Ulaanbaatar

Duke Matthews, Facilities Maintenance Officer
Myagmarsuren Jamyansuren, Painter/Carpenter
Enkhbat Zagdsuren, FMS Assistant
Ganbat Dondov, FMS Assistant
Crown Relocation crew

Vienna

Nathalie Mayer, Graphic Designer

Талархал

Вашингтон ДС

Сара Тангай, музейн эрхлэгч
Тереза Бийль, бүртгэгч
Марсиа Мейо, Ахлах редактор
Сали Мансфийлд, редактор
Аманда Брукс, зураг дүрслэлийн менежер

Улаанбаатар дахь АНУ-ын Элчин Сайдын Яам

Дюк Матюүс, Барилгын хэлтсийн менежер
Мягмарсүрэн Жамьяансүрэн, мужаан
Энхбат Загдсүрэн, өрлөгчин
Ганбат Дондов, туслах ажилтан
Crown Relocation компанийн хамт олон

Вена

Натали Мэйер, график дизайнер



Published by ART in Embassies
U.S. Department of State, Washington, D.C.
January 2014